



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЦЭВЭЭНЖАВТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2011-7-21 № 3-1/3003

танай _____-ны № _____-т

Монгол Улсын 2012 оны төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулах тухай

Улсын Их Хурлын 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсантай холбогдуулан түүнд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012 оны төсвийн хязгаарыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон түүний хавсралтыг боловсруулан санал авахаар Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн билээ. Тогтоолын төсөлд Сангийн сайдын багцын хүрээнд 2012 оны төсөвт нийт 2,798,112.8 сая төгрөгийн орлогын доод хэмжээг төвлөрүүлэхээр тусгасан бөгөөд үүнээс 1,116,712.9 сая төгрөгийг Улсын гаалийн ерөнхий газар төвлөрүүлэхээр тооцсон болно.

Манай улсын хувьд уул уурхайн салбар хурдацтай хөгжиж, Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд уг салбараас оруулах хувийн жин ихээхэн нэмэгдэж байгаа боловч уул уурхайн салбараас орох орлогын төсвийн нийт орлогод эзлэх хувь удаан хугацаанд нэг түвшинд байсаар ирсэн. Гэвч байгаль орчны тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн асуудал хурцаар тавигдаж, хүн амын орлогын түвшний ялгаа өссөөр байна.

Эдгээр хүчин зүйлсийг харгалзан уул уурхайн бүтээгдэхүүнд ногдох экспортын татварын тухай хуулийн төслийг санаачлан 2012 оны төсвийн жилд хэрэгжүүлэх, уг татвараас орох орлогыг эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих, эдийн засгийн бусад салбар руу чиглүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Экспортын татвараас 2012 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг ойролцоогоор 300 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Иймд 2012 оны төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө болон экспортын татварын тухай хуулийн төслийг боловсруулж, бэлтгэл ажлыг ханган 2011 оны 8 дугаар сар 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт: 2012-2014 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон дагалдах хавсралтууд (мөн www.mof.gov.mn болон <http://iltod.gov.mn> вэб хаягаар хандан электрон хэлбэрээр авч болно)

ДЭД САЙД



Ч.ГАНХУЯГ

08 3056